



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/225/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
2023 он	Аудитор: З.Золбоо Утас: 7036-2442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	15-18
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.13 № СЭА-2023/225/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТАТВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЛХАГВАДОРЖ  
ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 83.6 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 16.4 хувиар хэмнэсэн байна.

Тайлант онд тус хэлтэс нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 130,264.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Татварын хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 82.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 20,574.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	төгрөгөөр
			Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,289,087.2</b>	<b>42,548,634.6</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>976,241.2</b>	-
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>976,241.2</b>	-
33510	Байгууллагаас авах авлага	976,241.2	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>31,312,846.0</b>	<b>42,548,634.6</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>31,312,846.0</b>	<b>42,548,634.6</b>
35410	Бичиг хэргийн материал	1,552,769.6	2,371,294.5
35420	Аж ахуйн материал	21,614,156.1	25,786,746.8
35440	Түлш, шатах тослох материал	840,000.0	502,830.0
35470	Бусад хангамжийн материал	7,305,920.3	13,887,763.3
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>299,522,465.9</b>	<b>231,006,840.0</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>299,522,465.9</b>	<b>231,006,840.0</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>286,616,465.9</b>	<b>218,100,840.0</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	22,156,836.2	52,866,836.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,938,555.4	-37,176,734.4
39203	Авто-тээврийн хэрэгсэл	160,800,000.0	113,300,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,548,633.5	-47,914,738.9
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	312,697,455.5	321,602,589.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-142,856,276.5	-197,237,197.5
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,869,251.2	33,603,840.1
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,412,929.4	-20,943,754.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,710,000.0	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,860,682.1	-
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>12,906,000.0</b>	<b>12,906,000.0</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	12,906,000.0	12,906,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>331,811,553.1</b>	<b>273,555,474.6</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>976,241.2</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>976,241.2</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>976,241.2</b>	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	976,241.2	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>330,835,311.9</b>	<b>273,555,474.6</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>330,835,311.9</b>	<b>273,555,474.6</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	369,861,425.8	369,861,425.8
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	369,861,425.8	369,861,425.8
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-39,026,113.9</b>	<b>-96,305,951.3</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-14,976,909.7	-39,026,113.9
51220	Тайлант үеийн үр дүн	-24,049,204.2	-57,279,837.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>331,811,553.1</b>	<b>273,555,474.6</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,095,703,803.3</b>	<b>1,178,682,902.0</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	<b>5,700,000.0</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	-	<b>5,700,000.0</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	-	<b>5,700,000.0</b>
110004	Хөрөнгө борлуулсны орлого	-	5,700,000.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>55,467,703.3</b>	<b>18,888,602.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>55,467,703.3</b>	<b>18,888,602.0</b>
120009	Бусад орлого	-	35,000.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,485,493.3	9,639,722.6
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,982,210.0	9,213,879.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,040,236,100.0</b>	<b>1,154,094,300.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,035,236,100.0</b>	<b>1,148,094,300.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,035,236,100.0	1,148,094,300.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,000,000.0</b>	<b>6,000,000.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.0	6,000,000.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,094,565,217.8</b>	<b>1,235,893,109.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,094,565,217.8</b>	<b>1,235,893,109.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,048,610,921.3</b>	<b>1,019,504,916.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>705,709,166.4</b>	<b>701,668,533.5</b>
210101	Үндсэн цалин	439,797,722.1	476,805,018.7
210102	Нэмэгдэл	125,803,446.6	83,864,183.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,894,174.4	65,686,333.9
210104	Урамшуулал	69,213,823.4	75,312,997.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>93,066,633.0</b>	<b>89,131,520.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,859,135.0	61,095,279.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,205,971.4	7,187,679.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,653,896.9	5,629,184.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,395,239.3	1,381,980.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,952,390.6	13,837,397.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,376,301.0</b>	<b>23,091,361.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	197,267.0	3,868,480.5
210302	Түлш, халаалт	6,766,086.0	15,677,397.0
210303	Цэвэр, бохир ус	112,948.0	3,545,484.0
210304	Байрны түрээс	37,300,000.0	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,205,003.4</b>	<b>17,422,115.5</b>
210401	Бичиг хэрэг	6,533,263.6	3,692,757.8
210402	Тээвэр, шатахуун	5,332,000.0	4,311,170.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,612,440.0	5,819,367.7
210404	Ном, хэвлэл	140,200.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.0	144,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,493,499.8	3,454,820.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,449,500.0</b>	<b>1,470,721.0</b>
210604	Урсгал засвар	3,449,500.0	1,470,721.0

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,944,000.0</b>	<b>3,185,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	8,944,000.0	3,185,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>72,124,103.2</b>	<b>93,086,106.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,024,720.0	92,443,384.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	420,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.0	148,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,358,151.2	-
210807	Газрын төлбөр	12,552.0	12,552.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,280.0	17,270.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>89,736,214.2</b>	<b>90,449,558.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0	6,085,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,634,674.7	6,209,210.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,101,539.5	78,155,348.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,954,296.6</b>	<b>216,388,192.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,720,000.0</b>	<b>22,934,900.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,574,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,720,000.0	2,360,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>43,234,296.6</b>	<b>193,453,292.9</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,234,296.6	187,803,292.9
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,650,000.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,138,585.5</b>	<b>-57,210,207.4</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>25,187,789.7</b>	<b>69,630.0</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	25,187,789.7	69,630.0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-24,049,204.2</b>	<b>-57,279,837.4</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,040,236,100.0</b>	<b>1,159,829,300.0</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	5,700,000.0
110	<b>Орлогын албан татвар</b>	-	5,700,000.0
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	-	5,700,000.0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	-	5,700,000.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	35,000.0
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	35,000.0
120009	Бусад орлого	-	35,000.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,040,236,100.0</b>	<b>1,154,094,300.0</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,035,236,100.0</b>	<b>1,148,094,300.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,035,236,100.0	1,148,094,300.0
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,000,000.0</b>	<b>6,000,000.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.0	6,000,000.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,028,074,100.0</b>	<b>1,159,829,300.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,028,074,100.0</b>	<b>1,159,829,300.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>982,119,803.4</b>	<b>943,441,107.1</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>705,709,166.4</b>	<b>701,668,533.5</b>
210101	Үндсэн цалин	439,797,722.1	476,805,018.7
210102	Нэмэгдэл	125,803,446.6	83,864,183.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70,894,174.4	65,686,333.9
210104	Урамшуулал	69,213,823.4	75,312,997.9
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>93,066,633.0</b>	<b>89,131,520.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,859,135.0	61,095,279.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,205,971.4	7,187,679.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,653,896.9	5,629,184.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,395,239.3	1,381,980.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,952,390.6	13,837,397.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,376,301.0</b>	<b>23,091,361.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	197,267.0	3,868,480.5
210302	Түлш, халаалт	6,766,086.0	15,677,397.0
210303	Цэвэр, бохир ус	112,948.0	3,545,484.0
210304	Байрны түрээс	37,300,000.0	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,419,500.0</b>	<b>19,995,911.7</b>
210401	Бичиг хэрэг	6,571,300.0	4,575,762.0
210402	Тээвэр, шатахуун	6,172,000.0	3,974,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,612,440.0	5,894,223.7

210404	Ном, хэвлэл	231,200.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.0	144,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,738,960.0	5,407,926.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,882,590.0</b>	<b>1,802,500.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,088,000.0	-
210604	Урсгал засвар	6,794,590.0	1,802,500.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,944,000.0</b>	<b>3,185,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	8,944,000.0	3,185,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>73,401,712.0</b>	<b>93,013,780.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,932,300.0	92,388,328.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	420,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.0	148,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.0	44,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,733,460.0	-
210807	Газрын төлбөр	12,552.0	12,552.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,319,901.0</b>	<b>11,552,500.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0	6,085,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,319,901.0	5,467,500.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,954,296.6</b>	<b>216,388,192.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,720,000.0</b>	<b>22,934,900.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,574,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,720,000.0	2,360,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>43,234,296.6</b>	<b>187,803,292.9</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,234,296.6	187,803,292.9
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>5,650,000.0</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,650,000.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>12,162,000.0</b>	<b>-</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>12,162,000.0</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,162,000.0</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,162,000.0</b>	<b>-</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,162,000.0	-
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-12,162,000.0</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.8	-	-14,976,909.7	354,884,516.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.8	-	-14,976,909.7	354,884,516.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-24,049,204.2	-24,049,204.2
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.8	-	-39,026,113.9	330,835,311.9
7	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	369,861,425.8	-	-39,026,113.9	330,835,311.9
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.8	-	-39,026,113.9	330,835,311.9
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-	-	-57,279,837.4	-57,279,837.4
12	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.8	-	-96,305,951.3	273,555,474.6

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,148,094,300.0</b>	<b>960,291,007.1</b>	187,803,292.9	83.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,148,094,300.0</b>	<b>960,291,007.1</b>	187,803,292.9	83.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,125,159,400.0</b>	<b>937,356,107.1</b>	187,803,292.9	83.3
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>831,932,900.0</b>	<b>701,668,533.5</b>	130,264,366.5	84.3
210101	Үндсэн цалин	504,847,700.0	476,805,018.7	28,042,681.3	94.4
210102	Нэмэгдэл	140,507,900.0	83,864,183.0	56,643,717.0	59.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,764,000.0	65,686,333.9	17,077,666.1	79.4
210104	Урамшуулал	103,813,300.0	75,312,997.9	28,500,302.1	72.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>103,991,600.0</b>	<b>89,131,520.4</b>	14,860,079.6	85.7
210201	Тэтгэврийн даатгал	70,714,300.0	61,095,279.4	9,619,020.6	86.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,319,300.0	7,187,679.9	1,131,620.1	86.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,655,500.0	5,629,184.0	1,026,316.0	84.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,663,900.0	1,381,980.0	281,920.0	83.1
210205	Эрүүл мэндийн даатгал	16,638,600.0	13,837,397.2	2,801,202.8	83.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,728,800.0</b>	<b>23,091,361.5</b>	40,637,438.5	36.2
210301	Гэрэл, цахилгаан	4,800,000.0	3,868,480.5	931,519.5	80.6
210302	Түлш, халаалт	54,128,800.0	15,677,397.0	38,451,403.0	29.0
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.0	3,545,484.0	1,254,516.0	73.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,223,300.0</b>	<b>19,995,911.7</b>	1,227,388.3	94.2
210401	Бичиг хэрэг	4,155,900.0	4,575,762.0	-419,862.0	110.1
210402	Тээвэр, шатахуун	3,974,000.0	3,974,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,135,800.0	5,894,223.7	1,241,576.3	82.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	549,600.0	144,000.0	405,600.0	26.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,408,000.0	5,407,926.0	74.0	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,802,700.0</b>	<b>1,802,500.0</b>	200.0	100.0
210604	Урсгал засвар	1,802,700.0	1,802,500.0	200.0	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,185,000.0</b>	<b>3,185,000.0</b>	-	100.0
210702	Дотоод албан томилолт	3,185,000.0	3,185,000.0	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>93,827,600.0</b>	<b>93,013,780.0</b>	813,820.0	99.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	93,171,400.0	92,388,328.0	783,072.0	99.2
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.0	420,200.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,400.0	148,700.0	8,700.0	94.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.0	44,000.0	22,000.0	66.7
210807	Газрын төлбөр	12,600.0	12,552.0	48.0	99.6

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,467,500.0	5,467,500.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,467,500.0	5,467,500.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,934,900.0	22,934,900.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,934,900.0	22,934,900.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,574,900.0	20,574,900.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,360,000.0	2,360,000.0	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,148,094,300.0	960,291,007.1	187,803,292.9	83.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,148,094,300.0	960,291,007.1	187,803,292.9	83.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,148,094,300.0	960,291,007.1	187,803,292.9	83.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,035,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,035,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	6,035,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,035,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,035,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,035,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,035,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,000,000.0
120009	Бусад орлого	-	35,000.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

---

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс /Татварын хэлтэс/ нь 2022 оныг **Татварын боловсролын жил** болгох зорилтын хүрээнд “Татварын хууль тогтоомж даган мөрдөлтийн эрсдэлийг удирдах, хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөлтийг олон улсын түвшинд хүргэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатны хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд Татварын ерөнхий газрын “Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар”-аас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан “Монголын татварын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг харьяа байгууллагууд дагаж мөрдөхөөр баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,256.0 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	976.2	-	(976.2)
Бараа материал	31,312.8	42,548.6	11,235.8
Үндсэн хөрөнгө	299,522.5	231,006.8	(68,515.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>331,811.5</b>	<b>273,555.5</b>	<b>(58,256.0)</b>
Өр төлбөр	976.2	-	(976.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	330,835.3	273,555.5	(57,279.8)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>331,811.5</b>	<b>273,555.5</b>	<b>(58,256.0)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 42,548.6 мянган төгрөг болж 11,235.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18,863.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ТЕГ-аас 9,213.9 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 16,841.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 534,279.6 мянган төгрөг болж 37,860.2 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2022 оны А-1/409, А-1/2429 дугаар албан бичгийн дагуу 9,639.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг ТЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авч, 2022 оны 498 дугаар тогтоолыг үндэслэн 47,500.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 273,555.5 мянган төгрөг болж 57,279.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг тус бүр 1,631,230.1 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид санал хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зардлыг 515,407.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,115,822.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийн саналаас хангамж, бараа материалын зардлыг 35,492.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 45,464.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлыг 37,818.4 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 84,613.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 229,600.0 мянган төгрөгөөр тус тус бууруулснаас шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 32,271.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,148,094.3 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,148,094.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,148,094.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 960,291.0 мянган төгрөг буюу 83.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 187,803.3 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,031,988.0	844,967.8	187,020.2	81.9
2	Харуул, хамгаалалтын зардал	28,800.0	28,800.0	-	100.0
3	Холбооны суваг ашигласны хөлс	64,371.4	63,588.3	783.1	98.8
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	22,934.9	22,934.9	-	100.0
	<b>Дүн</b>	<b>1,148,094.3</b>	<b>960,291.0</b>	<b>187,803.3</b>	<b>83.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс татвар төлөгчдийн өдрүүдэд 4,000.0 мянган төгрөг, шилдэг агентлагийн шагналд 2,000.0 мянган төгрөг, ТӨБЗГ-аас худалдан авах ажиллагааны орлого 35.0 мянган төгрөгийн зэрэг нийт 6,035.0 мянган төгрөг төвлөрч, бараа зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус байгууллагад Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах болон зардлыг бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 51 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,094,565.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,418.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТЕГ-аас “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл” цахим хурлыг зохион байгуулж харьяа газруудад чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,
- Сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрт шилжүүлж холбогдон гарах зардлыг хэмнэсэн,
- Албан хаагчдад татвар төлөгчтэй холбоо барих гар утасны зардал олголтыг зогсоосон,
- Байгууллагын цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж, өр төлбөргүй тайлагнагдсан гэх мэт.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Татварын хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 164-ийг хугацаанд нь мэдээлсэн бол 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлж, тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэв.

Завсрын үеийн аудитаар түлш, шатахууны тайланд 263.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалт нь жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй байхад зардлаар бүртгэж, бүртгэл тайланд тусгасан зөрчил илэрснийг залруулж, зарцуулалтын тайланг гаргуулж, хянаж баталгаажуулав.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй 2,983.4 мянган төгрөгийн зөрчил болон бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй 33,554.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	36,537.4	2	36,537.4	100
Нийт дүн	2	36,537.4	2	36,537.4	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 880.0 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрсэнд зөвлөмж өгсөн.

#### 5.1 Зөвлөмж

##### 1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Төсвийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ шаардлага, судалгаанд үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс маргаан таслах зөвлөлийн гишүүдийн хөлс 880.0 мянган төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас санхүүжүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Зардлыг бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Төсвийг бодитоор үнэн зөв төлөвлөөгүй	1	880.0					1	880.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>880.0</b>					<b>1</b>	<b>880.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	3	-						3	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>						<b>3</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>-</b>						<b>3</b>	<b>-</b>